

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Доржийн Гэрэлтуяа

**Хөнгөлөлттэй үнээр үйлчлэх зайлшгүй
шаардлагатай эмийн олголт, үнийн
мөрдөлтөнд хийсэн судалгаа**

Е 720154 – Эм зүй

Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл

УЛААНБААТАР ХОТ
2008 он

Магистрын судалгааны ажлыг ЭМШУИС (Захирал, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Ц.Лхагвасүрэн), Эм зүйн сургууль (Захирал, Эм зүйн ухааны доктор, профессор С.Цэцэгмаа), Эм зүйн албаны зохион байгуулалт, эмийн технологийн тэнхим (Эрхлэгч, Эм зүйн ухааны доктор Ц.Даваасүрэн)-д хийж гүйцэтгэв.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Эм зүйн ухааны доктор, дэд профессор Р.Цэрэнлхагва

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Эм зүйн ухааны доктор М.Уранчимэг

Удиртгал

Судалгааны ажлын үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 68 дугаар тогтоолоор “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг баталсан. Уг бодлогын баримт бичигт тусгагдсан эмийн бодлогын зорилтуудын нэг нь хүн амыг шаардлагатай эмээр тасралтгүй жигд хүртээмжтэй хангах зорилт юм. Аливаа тусламж үйлчилгээ болон эмийн хүртээмж нь хүн амын худалдан авах чадвартай холбоотой. Иймд хүн амыг шаардлагатай эмээр тэгш хүртээмжтэй хангах зорилтыг хэрэгжүүлэх нэг нөхцөл нь санхүүжилтийн асуудал байдаг юм [6,7].

Мөн Монгол улсын засгийн газраас эрүүл мэндийн санхүүжилтийн үр ашиг, үр дүнг сайжруулах үүднээс урьдчилан сэргийлэх болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг түлхүү хөгжүүлэх бодлогыг баримталж байна [2,4].

“Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль”-д зааснаар хүн амын тодорхой бүлэг болох 0-16 хүртлэх насны хүүхэд (ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй бол 18 нас хүртэлх), тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, хүүхдээ 2 нас (ихэр бол 3 нас) хүртэл өсгөн бойжуулахаар чөлөө авсан эх, “Нийгмийн халамжийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлд заасан иргэн, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч-цэрэг зэрэг 1.7 сая орчим иргэний эрүүл мэндийн даатгалын хураамжийг төр хариуцаж байна [1,3,9].

Эрүүл мэндийн даатгалын хураамжийг нь төр хариуцдаг тодорхой бүлэгт багтах дээрх иргэдэд эмнэлгийн амбулатори, поликлиникээр үйлчлүүлж өвчний оношоо тогтоолгож, эмчилгээнд бичигдсэн “Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт”-д орсон тодорхой нэрийн эмийг эрх олгогдсон эмийн сангаас даатгалын жороор авахад үнэнд тодорхой хувийн хөнгөлөлт үзүүлж, түүний зөрүүг эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олгож байхаар заасан юм [2,6,7].

Монгол улсын хүн амын 60 гаруй хувийг эзлэх тодорхой бүлгийн иргэдэд хууль тогтоомжинд заасан эрүүл мэндийн төлбөргүй тусламж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтийг зохих журмын дагуу үзүүлж, тэдний эрүүл мэндийг сайжруулах асуудал нь эрүүл мэндийн салбарын бодлогын нэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь болж байгаа билээ.

Энэхүү үндсэн асуудлыг иш үндэс болгон иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үнийн хөнгөлөлттэй эмээр үйлчлэх үйл ажиллагаа хууль тогтоомжинд заасны дагуу хэрхэн явагдаж байгааг судлан үнэлгээ хийж, цаашдын үйл ажиллагааны чиглэлээр санал дэвшүүлэх нь уг судалгааны ажлыг явуулах үндэслэл болж өглөө.

Судалгааны ажлын зорилго, зорилтууд:

Монгол улсын хууль тогтоомжид заагдсаны дагуу хүн амын дээрх бүлэгт хамаарагдах иргэдэд “Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт”-д орсон зарим нэрийн эмийг хөнгөлөлттэй үнээр, эрх олгогдсон эмийн сангуудаас олгож байгаа байдал болон үнийн мөрдөлтөнд судалгаа хийж санал дэвшүүлэхэд үндсэн зорилго чиглэгдэв.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тавьлаа. Үүнд:

1. ЭМД-ын сангаас үнийн хөнгөлөлтөнд зарцуулсан санхүүжилт, хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлэгчдийн тоог бүсчилсэн байдлаар, аймаг, нийслэлээр, оноор судлаж нэгдсэн дүнг гаргах.
2. Монгол улсын “Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт”-д орсон эмийг хөнгөлөлттэй үнээр олгож буй байдал, даатгалын жороор хөнгөлөлттэй олгох зайлшгүй шаардлагатай эмийн олголт, эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөнд олгогдсон төлбөрийн хувийг тооцоолон гаргах.
3. Хөнгөлөлттэй үнээр олгох зайлшгүй шаардлагатай эмийг эцсийн хэрэглэгчдэд олгож буй үнэ, үнийн дээд хязгаарын мөрдөлтийг судлан гаргах, Эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн төлбөр хийж байгаа байдалд судалгаа хийх.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Монгол улсын хүн амын тодорхой бүлэгт буюу орлогын эх үүсвэр багатай амьжиргааны түвшин доогуур иргэдэд эрүүл мэндийн зарим тусламж үйлчилгээг төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр үйлчлэх ажил төр засгийн эрх зүйн актуудын хүрээнд хэрхэн явагдаж байгаа байдлыг төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг бүсчилсэн байдлаар хамруулан үйл ажиллагааны тайлан, бүртгэлийн албан ёсны баримтуудад тулгуурлан судлаж, үнэлгээ хийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр цаашид анхаарах

асуудлууд, хийх ажлын талаар санал зөвлөмж дэвшүүлж тавьлаа.

Хүн амын тогтвортой амьжиргааг хангахад зохих дэмжлэг тусалцаа үзүүлэх, ядуурлыг бууруулах, эрүүл мэндийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр засгаас үзүүлж буй хөнгөлөлтийг эдлэх үйл ажиллагаа хэрхэн амьдралд биелэлээ олж байгаа байдлыг бодитойгоор судлан үнэлгээ хийсэн ажил үндсэндээ байхгүй нь уг судалгааны ажлын шинэлэг болохыг харуулж байгаа юм.

Судалгааны ажлын шинжлэх ухааны ба практикийн ач холбогдол:

Төр засгийн эрх зүйн актуудын хүрээнд тодорхой бүлэгт багтах иргэд эрүүл мэндийн төлбөргүй болон хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх эрхийг хэрхэн эдэлж, зөвшөөрөгдсөн тусламж үйлчилгээний хүртээмжийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан үнэлгээ хийж, цаашдын үйл ажиллагааны чиглэлээр санал зөвлөмжийг гарган тавьж байгаа нь энэхүү судалгааны ажлын шинжлэх ухааны болоод практик ач холбогдолтой болохыг харуулж байгаа юм.

Хөнгөлөлттэй үнийн эмээр үйлчлүүлсэн иргэдийн тоо, энэ үйлчилгээнд хамрагдалт, эмийн сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон нэр төрлийн эм олголт, эмийн үнийн мөрдөлтийн байдлыг Монгол улсын бүс нутгийн хэмжээгээр судлан тогтоолоо.

I. Судалгааны ажлын үндэслэл

1.1. Монгол улсын эдийн засаг, хүн амын амьжиргааны түвшин, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны санхүүжилт, даатгалын тогтолцоо

Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт суурилсан, хүний эрхийг дээдэлсэн иргэний ардчилсан нийгмийг байгуулах үйлсийг эхэлж, улмаар нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэлт хийж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явцыг эргэлт буцалтгүй сонгосон билээ.

1998 онд хийсэн судалгаагаар нийт хүн амын 35.6%, хот суурин газрын хүн амын 39.4%, хөдөөгийн хүн амын 32.6%-нь ядуу амьдарч байна гэсэн дүн гарчээ. Хүн амын ажил эрхлэлтийн түвшин 59.3%, ажилгүйдлийн түвшин 4.6% байна [9].

Дүгнэлт

1. 2003 онд Эрүүл Мэндийн Даатгалын Сангаас 482055 даатгуулагчид үнийн хөнгөлөлтөнд 381.8 сая төгрөг зарцуулж байсан бол энэ үзүүлэлт 2006 онд 460510 даатгуулагчид 564.5 сая төгрөг болж, олгосон хөрөнгийн хэмжээ өссөн хэдийч, хөнгөлөлттэй олгох эм авсан иргэдийн тоо буурсан байна. Нийт даатгуулагчийн 27.09 хувь буюу 460,510 даатгуулагч хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлсэн байна. Хөнгөлөлттэй үнээр олгох эм авсан үйлчлүүлэгчдийн тоог бүсчилсэн байдлаар гарган харьцуулалтахад баруун бүсийн аймгуудад хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлэгчдийн тоо 2003 онд 59636 байсан бол 2006 онд 70193, хойд бүсэд 97768-аас 135171, зүүн бүсэд 41360-аас 63052, говийн бүсийн аймгуудад 64132-оос 70545, нийслэл хотод 32536-аас 37414 болж өссөн байлаа. 2003 оноос 2006 оны явцад төвийн бүсийн аймгуудад хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлэгчдийн тоо 186353-аас 84135-д хүртэл буурсан байна.

2. ЭМД-аас эмийн үнийн хөнгөлөлтөнд зарцуулсан санхүүжилтийг бүсчилсэн байдлаар судлан үзэхэд хойд буюу хангайн бүсийн аймгуудад хамгийн их (166.8 сая төг буюу 30.0%), төв, баруун аймгуудад тус тус 90 сая төг буюу 16 хувь, зүүн бүсийн аймгуудад 86.07 сая төг буюу 15 %, говийн бүсийн аймгуудад хамгийн бага (81.2 сая төг буюу 14 %) байна.

3. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн олголт эмийн сангуудад дунджаар 44.51 хувь, фармакологийн бүлгээр нь авч үзвэл шээс хөөх эм (78.57%), амин дэм, эрдэс бодис (70.94%), оношлогооны бодис, нүдний бэлдмэлүүд (59.74%), уналт, таталтыг эмчлэх эм (57.03%), өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг нөлөөлөх стероид бус эм (55.56%), харшлын эсрэг ба анафилаксийн эсрэг бэлдмэл (52.38%), антидот ба хордлого тайлах эм (23.81%), халдварын эсрэг бэлдмэл (16.33%)-үүд байна. Хөнгөлөлттэй үнээр олгох эмийн үнийн мөрдөлт судалгаанд хамрагдсан эмийн сангуудад дунджаар 38.69 % байна. Хөнгөлөлттэй үнээр олгох эмийн үнийн дээд хязгаарын мөрдөлтийг өвчлөлийн ангилалаар авч үзвэл ходоод гэдэсний замын өвчнийг эмчлэх эмүүдэд хамгийн өндөр буюу 85.71 хувь, цусанд нөлөөлөх эмэнд 14.29 хувьтай буюу үнийн мөрдөлт хамгийн муу үзүүлэлттэй байна.

Санал, зөвлөмж

1. Эрүүл мэндийн даатгал болон хөнгөлөлттэй үнээр олгох зайлшгүй шаардлагатай эмийн талаархи мэдлэгийг сайжруулахын тулд иргэд, эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд, эмийн мэргэжилтнүүдэд зориулсан богино хугацааны сургалтыг хот, хөдөөд тухайн орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллага, Эрүүл мэндийн газар хамтран тогтмол зохион байгуулах
2. Эмийн сангуудын үйл ажиллагаанд хөнгөлөлттэй үнээр олгох эмийн нэр төрөл бүрдүүлэлт, үнийн дээд хязгаарын мөрдөлтөд тавих хяналтыг тогтмолжуулах
3. Эмийг жороор олгох журам, жор бичилтийн улсын стандартын мөрдөлтийг сайжруулах
4. Эмийг жороор олгох журам, жор бичилтийн улсын стандартыг бусдад нээлттэй, хүрэлцэхүйц байлгахад эмч, эмийн санч, Нийгмийн даатгалын газрын эрх бүхий мэргэжилтнүүд хамтран ажиллах
5. Эмнэлгийн мэргэжилтний дипломын дараах мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт эмийн жор бичилт, жороор олголт, эрүүл мэндийн даатгал, хууль эрх зүйн асуудлуудыг тогтмол оруулж сургалт явуулдаг хэвшлийг төлөвшүүлэх
6. Хөнгөлөлттэй үнээр олгох эмийн үнийн дээд хязгаарын мөрдөлтийг сайжруулахын тулд:
 - Импортоор оруулж ирэх зайлшгүй шаардлагатай эмийг улсын бүртгэлд бүртгэхдээ үнийн дээд хязгаарыг тогтоож өгч байх
 - Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас эмийн сангуудад уг эмүүдийг олгохдоо баримталж буй хорогдолын хэмжээний хяналт, зохицуулалтыг хийж байх
 - Эцсийн хэрэглэгчдэд олгож буй жижиглэн худалдаалах үнэ бүрдэлт шудрага журмаар явагдаж буй эсэхэд эрх бүхий байгууллагууд хяналт, зохицуулалт хийж байх шаардлагатай

- Нөгөө талаар хөнгөлөлттэй үнээр олгох эмийн жагсаалт, түүний үнийн дээд хязгаарыг тогтоох үндэслэлийг сайжруулах нь зүйтэй гэж үзнэ.
7. Тодорхой бүлгийн иргэдийн дунд түгээмэл буюу олонтаа тохиолддог өвчнүүдийн үндсэн эмчилгээний зайлшгүй шаардлагатай эмүүдийг хөнгөлөлттэй үнээр олгох эмийн жагсаалтад цаашид өргөн хамруулах нь зүйтэй гэж үзэж байна.
 8. Хөнгөлөлттэй үнээр олгож, үнийн зөрүүг Эрүүл мэндийн даатгалын сангаас нөхөн олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлийн жагсаалт, мөрдөх үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хувийг тогтоох үйл ажиллагаанд холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсийг өргөн оролцуулж, тэдний санал хүсэлтийг авч тусгаж байх.
 9. Эрүүл мэндийн даатгалын жор бичилт, уг эмийн олголт, хөрөнгийн санхүүжилтийг хугацаанд нь хийх, хууль тогтоомжинд зааснаар хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулах хариуцлагыг дээшлүүлж, хяналтыг тогтмолжуулах нь зүйтэй.

Гарчиг

Удиртгал	1
Судалгааны ажлын үндэслэл	1
Судалгааны ажлын зорилго, зорилтууд	1
Судалгааны ажлын шинэлэг тал	2
Судалгааны ажлын шинжлэх ухааны ба практикийн ач холбогдол	3
Нэгдүгээр бүлэг. Хэвлэлийн тойм	3
1.1. Монгол улсын эдийн засаг, хүн амын амьжиргааны түвшин, эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны санхүүжилт, даатгалын тогтолцоо	3
1.2. Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн 5 дахь жагсаалт	20
1.3. Монгол улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хамрах хүрээ, зохицуулалт, эрүүл мэндийн даатгал, сан бүрдүүлэлт, түүний хуваарилалт, зарцуулалт	22
Хоёрдугаар бүлэг. Судалгааны объект, материал, арга зүй	37
Гуравдугаар бүлэг. Судалгааны үр дүн ба хэлцэмж	39
3.1. Эрүүл мэндийн даатгалын хураамжийг нь төр хариуцдаг иргэд даатгалын жороор зарим зайлшгүй шаардлагатай эмийг хөнгөлөлттэй үнээр авах үйлчилгээнд хамрагдалт, Эрүүл мэндийн даатгалын сан (ЭМДС)-гаас олгосон хөрөнгийн байдалд хийсэн судалгааны үр дүн	39

3.2. Эрүүл мэндийн даатгалын хураамжийг нь төрөөс хариуцдаг иргэдэд даатгалын жороор зарим зайлшгүй шаардлагатай эмийг хөнгөлөлттэй үнээр олгох үйл ажиллагаанд хийсэн судалгааны үр дүн	44
3.3. Хөнгөлөлттэй үнээр олгох зайлшгүй шаардлагатай эмийг эцсийн хэрэглэгчдэд олгож буй үнэ, үнийн дээд хязгаарын мөрдөлтөнд хийсэн судалгааны үр дүн	50
Дүгнэлт	53
Санал, зөвлөмж	54
Ашигласан ном зүй	58
Товчилсон үгийн жагсаалт	60

Ашигласан ном зүй

- Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль, 12 дугаар зүйл
- Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, 1998 он
- Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, 9-р зүйл, 9.2.2 зүйл, 12.9
- Монгол Улсын Хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1994 он
- Монголын Үндэсний Статистикийн мэдээлэл, 2006 он
- Монгол Улсын Их Хурлын 68-р тогтоол, “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, Улаанбаатар, 2002 он
- Монгол Улсын “Эмийн тухай хууль”, Улаанбаатар, 2002 он
- Монгол Улсын Эрүүл мэндийн статистикийн тайлан, 1999-2007, ЭМЯ <http://www.moh.mn>
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдлыг тухай танилцуулга, 2006 оны 12-р сар
- Нийгмийн даатгалын газрын тайлан, Улаанбаатар, 2007 он
- Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, Монгол Улсын Засгийн Газар, Улаанбаатар, 2003 он, хх.1-12, 24- 26, 46-54, 65-73, х.164, 184
- Эрүүл Мэндийн Даатгалын гарын авлага, хх. 26-32, Улаанбаатар хот, 2007
- Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлтөнд зарцуулсан зардлын судалгаа, 2000-2004 он, хх. 66-68, Нийгмийн даатгалын салбарын хөгжил, тулгамдсан асуудлууд, Улаанбаатар хот 2007 он
- Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, ЭМЯ, ЭМҮХТ, хх. 6-7, 2006 он
- Эрүүл мэндийн төсвийн тайлан, 1999-2004 он, ЭМЯ, <http://www.moh.mn>
- “Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийг “Зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалт”-д заасан эмээр эмчлэх зардал, түүний санхүүжилтэд хийсэн эдийн засгийн шинжилгээ”, Р.Цэрэнлхагва, Ч.Мөнхдэлгэр
- Antonakis N, Xylouri I, Alexandrakis M, Cavoura C, Lionis C. Seeking prescribing patterns in rural Crete: a pharmacoepidemiological study from a primary care area: Rural and Remote Health 6:488, 2006
- Carrin, pp. 5-8, 2002

Carol Beaver, Review of Expenditure and Finance of Medicines in Mongolia 2006, pp.20-32

How to develop and implement a national pharmaceutical policy, Second edition, 1988 WHO Geneva p.37

How to investigate drug use in health facilities”, Action Programme on Essential Drugs, WHO, Management Sciences for Health INRUD

Irrational use of drugs in India, Patel V. et. al., retrived in Sep. 2007 from:
www.jpgmonline.com

Management Sciences for Health in collaboration with the World Health Organization Managing Pharmaceuticals Supply, Kumarian Press 1997, p.609

National Health Accounts: The Methodology and Implementation Process, Maryland, USE 2003, quoted in Schubert C Review of Expenditure and Financing of Medicines in Selected Pacific Island Countries p.5

Prevalence and current situation of iron deficiency anemia among pregnant women in aimag and districts of Mongolia, 2004, accessed in September 2007,
<http://www.moh.mn>

Rokstad K, Straand J, Fugelli P. General practitioner’s drug prescribing practice and diagnoses for Prescribing: The M&Romsdal prescription study. Journal of Clinical Epidemiology 1997;50:485-494

Roy Harvey, Social Health Insurance, Selected Case Studies from Asia and the Pacific, pp.81-91